



№08 (147)

2023 оны 08-р сар

"ДЦС-4" ТӨХК-ийн сар тутмын сонин

ЭНЭ ДУГААРТ:

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

2-р нүүрт

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

3-р нүүрт

ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

4-р нүүрт

ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУДАД ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ

5-р нүүрт

2023 ОНЫ 8-Р САРЫН ТЭЗҮ

6-р нүүрт

2023 ОНЫ 8-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

7-р нүүрт

СНАТ ГРТ ГЭЖ ЮУ?

8-р нүүрт



Сонины талаарх санал хүсэлтээ 2125, 2602 дугаарын утас, cxa@

tpp4.mn эсвэл СХА-нд файлаар болон бичгээр өгч болно.

www.tpp4.mn/erchim

МЭНДЧИЛГЭЭ

Тэртээх 1979 онд Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц гэх их айлын шавыг тавьж, 1983 оноос гал голомтоо бадраан цахилгаан, дулаан үйлдвэрлэж эхэлснээс хойш эдүүгээ 40 жил эх орныхоо хөгжлийн баталгаа, эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байх эрхэм зорилгоо чандлан биелүүлж, их түүхийг бүтээлцсэн станцыгаа үе үеийн ахмадууд, ажилч хичээнгүй хамт олноороо бахархаж байна.

Монгол улсынхаа бүтээн байгуулалтанд түүчээлэн оролцож, нийгэм эдийн засгийн хүнд хямралтай он жилүүдэд ч бэрхшээл бүхнийг даван туулж, эх орон ард түмэн нийслэлчүүдийнхээ итгэлийг алдаагүй энэхүү түүхт 40 жилийн хугацаанд 100.0 тэрбум кВтц цахилгаан эрчим хүч, 100.0 сая гКал дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн түгээж, 3.6 их наяд төгрөгийн орлоготой ажиллан эх орныхоо хөгжлийн үндэс суурь, эдийн засгийн өсөлтийг хангах гол хүч болж ирсэн.

40 жилийн өмнө 380 МВт хүчин чадалтай станц жилд 500.0 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байсан бол өдгөө 772 МВт-ын хүчин чадалтай болж, жилд 4.6 тэрбум кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, үйлдвэрлэл 9 дахин өссөн байгааг дурдахад таатай байна.

1995-2020 онуудад Япон улсын хөнгөлөлттэй зээл, тусламжийн хүрээнд зуухны тоосон системийн шинэчлэл болон зуух, турбины хяналт удирдлагын системийг бүрэн автоматжуулснаар тогтвортой найдвартай ажиллагаа дээшилсэн. Мөн ОХУ-ын хөнгөлөлттэй зээл, Монгол улсын Хөгжлийн банкны



"ДЦС-4" ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАН Ү.ТӨМӨРХҮЯГ

санхүүжилтээр турбоагрегатуудын шинэчлэлийн үр дүнд суурилагдсан хүчин чадал 212 МВт-аар нэмэгдсэн.

Эв нэгдэл, эрхэм зорилго дор нэгдэж, эрчим хүчний салбарын хүчирхэг тулгуур нь болж яваа манай хамт олны дундаас Монгол улсын Хөдөлмөрийн баатар С.Балдорж, П.Дамбийбазар, Монгол улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан С.Дагвадорж, С.Гэрэл, Д.Хэнмэдэх, Ц.Баярбаатар, Ц.Батхүү, Б.Цэвээн, Ч.Энхтуяа, Г.Ёндонгомбо, Ж.Осгонбаатар, Б.Дашдаваа нарын алдар гавьяатнууд, хөдөлмөрийн сайчууд төрөн гарсан.

Эх орныхоо дөрвөн зүгтээ илчээ түгээсэн 4 дүгээр цахилгаан станцынхаа үе үеийн ахмадууд, инженер техникийн ажилтан, ажиллагсад, тэдний гэр бүл болон мэргэжил нэгт салбарын хамт олондоо "Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон"-т "ДЦС-4" ТӨХК-ийнхаа түүхт 40 жилийн ойн баярын халуун мэндчилгээг өргөн дэвшүүлье.



"ДЦС-4" ТӨХК-ийн ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР, МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР П.БОЛДБААТАР

Монгол улсын хөгжлийн зам мөртэй зэрэгцэн цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаа энэ үед, үе үеийн чадварлаг инженер техникийн ажилтан, ажилчдын чин сэтгэл, хичээл зүтгэл, мэргэжлийн нарийн мэдрэмж, техник технологийн бодит боломжийг тооцон олон төсөл хөтөлбөрийг богино хугацаанд үе шагтайгаар хэрэгжүүлж чадсан нь түүхэн бахархалт 40 жилийн ойдоо бидний барьж буй бэлэг билээ.

Үйлдвэрлэлийг тогтмол нэмэгдүүлж, жигд найдвартай ажиллагааг хангах, техник технологийн

шинэчлэлийг үр ашигтай явуулах, бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах замаар үйл ажиллагааны ашгийг өндөрсгөх эрхэм зорилгыг биелүүлэхийн тулд засвар, ашиглалтын ажлын чанарыг өндөр түвшинд гаргах, ажиллагсдын мэргэжлийн түвшин, ур чадварыг дээшлүүлэн, тэдний оюуны чадавхийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх, компанийн нэр төрийг үргэлж өндөрт байлгаж, ажиллагсдын сэтгэл зүй, нийгмийн төлөвшилийг бий болгох зэрэг олон асуудлыг тодорхой дэс дараатай шийдвэрлэсэн нь өнөөдрийн хамт олны амжилтын үндэс болж байна.

Монгол эх орныхоо Эрчим хүчний гал голомтыг бахархалтайгаар авч яваа "ДЦС-4" ТӨХК-ийн маань түүхт 40 жилийн ойн баярыг тохиолдуулан эрчим хүч хэрэглэгчиддээ хамгийн хямд цахилгаан, дулааны эрчим хүчээр найдвартай, тасралтгүй хангах нь нөр их хөдөлмөр, цуцалтгүй шаргуу зүтгэл, бахархам сайхан амжилтын илэрхийлэл хэмээн, энэ сайхан буянтай үйлсийг бүтээхэд өөрийн хувь нэмэр авьяас чадвараа дайчлан ажиллаж байгаа хамт олон та бүхэндээ гүнээ талархахын ялдамд ажлын өндөр амжилт, гэр бүлд тань эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Хамт олны маань үйлс нь өвдрөг нэр төр нь хүндтэй байх болтугай.



ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД



“Дулааны 4 дүгээр цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 40 жилийн ойг тохиолдуулан монгол улсын хөгжил дэвшилд онцгой үүрэг гүйцэтгэж, эрчим хүчний салбарыг бэхжүүлэх, хэрэглэгчдийг цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй, найдвартай хангах үйлсэд жинтэй хувь нэмэр оруулан олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон медиалаар шагнагдсан ажилтнууд.

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ГООР

Самдангийн Алтанхуяг	Борлуулалт маркетингийн албаны дарга
Гачинламын Галбадрах	Судалгаа хөгжлийн албаны дарга
Үстийн Болд	Түлш дамжуулах цехийн нүүрсний нийлүүлэлт гэрээ хариуцсан ахлах мэргэжилтэн
Цэдэндоржийн Наранцацрал	Санхүү бүртгэлийн хэлтсийн материал сэлбэг хариуцсан нярав
Сум-Очирын Мөнх-Очир	Авто аж ахуйн дарга
Цэдэндоржийн Амарбаясгалан	Засварын албаны дарга
Очирхүүгийн Гантөмөр	Түлш дамжуулах цехийн ашиглалтын инженер

“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР

Совджамцын Жаргалсайхан	Нийгэм ахуйн хэлтсийн соёл урлагийн арга зүйч /ахмад ажилтан/
Гүндэвийн Наранцэцэг	Засварын албаны тоноглолын засварын төлөвлөлт, хяналтын инженер /ахмад ажилтан/
Батаагийн Эрдэнэбаатар	Түлш дамжуулах цехийн хөдөлгүүр өргөх зөөх механизмын мастер /ахмад ажилтан/
Очирбатын Оюунчимэг	Эмнэлгийн яаралтай тусламжийн бага эмч /ахмад ажилтан/
Буджавын Уранчимэг	Цахилгаан цехийн диспетчерийн холбооны ашиглалтын монтер /ахмад ажилтан/
Лүндэгийн Очгэрэл	Захиргаа хүний нөөцийн албаны албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн
Пунцагдоржийн Ганбат	Механик цехийн агаар задлагчийн аппаратчин ээлжийн ахлагч
Даваагийн Сэрдамба	Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн хэмжүүрийн засварчин
Хадхүүгийн Очирсүрэн	Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн хэмжүүрийн засварчин
Төмөрбаатарын Оюунтуяа	Эрчим зоог цайны газрын ээлжийн ахлах тогооч
Жамъяндолгорын Батгэрэл	Дулааны хянах хэмжүүр автоматикийн цехийн програмчлалт автоматикийн инженер
Дашдоржийн Энхболд	Механик цехийн засварын инженер /асан/
Пунцагноровын Баяр-Эрдэнэ	Түлш дамжуулах цехийн дарга
Лхагважавын Гантуяа	Цахилгаан цехийн цахилгаан машины ороомог хөндийрүүлгийн цахилгааны монтер
Раднаагийн Нандинцэцэг	Турбин цехийн турбины машинч

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР

Чойжилсүрэнгийн Энхбаатар	Турбин цехийн тосны аж ахуйн засварчин /ахмад ажилтан/
Андрушийн Ариунболд	Турбин цехийн ахлах машинч
Балдангомбын Ганбат	Зуухан цехийн зуухны машинч
Бямбажавын Энхбаяр	Цахилгаан цехийн цахилгаан машины засварын цахилгааны слесарь
Шаравжамцын Дархан-Эрдэнэ	Зуухан цехийн бул сэргээн засварлах, өргөх зөөх механизмын засварын инженер
Нохойжавын Галцог	Судалгаа хөгжлийн албаны мэдээлэл технологи хариуцсан ахлах инженер
Магсарсүрэнгийн Доржготов	Зуухан цехийн туслах тоноглолын машинч
Пашпунцагийн Цэрэндаш	Цахилгаан цехийн төв корпусын реле хамгаалалт автоматикийн инженер
Хадаагийн Оюунтуяа	Эмнэлгийн яаралтай тусламжийн бага эмч
Бадамхатангийн Бадмаараг	Авто аж ахуйн жолооч
Жүрмэддоржийн Батбаяр	Түлш дамжуулах цехийн ээлжийн цахилгааны монтер
Норовцэрэнгийн Наранцэцэг	Цахилгаан цехийн засварын технологийн мастер
Батсуурийн Сампилноров	Борлуулалт маркетингийн албаны дулааны шугам сүлжээний инженер
Буурайгийн Тэгшбаяр	Түлш дамжуулах цехийн туузан тэжээгчийн машинч
Нямдаасүрэнгийн Нямдагва	Зуухан цехийн зуух болон тоос бэлтгэх тоноглолын засварчин
Долгорын Ганхуяг	Турбин цехийн халах гадаргуун засварчин
Баярын Соёл-Эрдэнэ	Эрчим зоог цайны газрын тогооч
Даваагийн Алтанцэцэг	Эмнэлгийн яаралтай тусламжийн бага эмч
Пунцагийн Батнайман	Хими цехийн ахлах машинч /ахмад ажилтан/
Лхагвасүрэнгийн Бямбасүрэн	Турбин цехийн эргэх механизмын засварчин
Баасанжавын Нямдолгор	Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн нормчлолын инженер
Ням-Осорын Мөнхбаяр	Хими цехийн технологич инженер
Батсүхийн Амарүвшин	Хяналтын албаны цахилгаан тоноглолын хяналтын инженер
Дагвадоржийн Сайханхүү	Хими цехийн дарга
Рэнцэнжүгдэрийн Баттулга	Засварын албаны арматур халах гадаргуун засварчин



ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ГООР



“АЛТАН ГАДАС ОДОН”-ГООР



“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР





ТӨРИЙН ДЭЭД ОДОН МЕДАЛИАР ШАГНАГДСАН АЖИЛТНУУД



“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР





КОМПАНИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТНУУДАД ШАГНАЛ ГАРДУУЛАХ ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭ



Компанийн 40 жилийн ойн баярт зориулсан бэлэг гардуулах ёслолын арга хэмжээг 09 сарын 13-ны өдөр хүндэтгэлийн талбайд зохион байгуулж, нэгжийг төлөөлүүлэн хамгийн олон жил ажилласан болон хамгийн сүүлд ажилд орсон ажилчдад компанийн 40 жилийн ойн гарын бэлгийг гардуулж өгөв.

Мөн Эрчим хүчний Тэргүүний ажилтан цол тэмдгээр ҮА-ны ээлжийн инженер Х.Чулуун-Эрдэнэ, ЭХ-ний зохицуулах хорооны хүндэт тэмдгээр ТЭЗХ-ийн ахлах эдийн засагч Ж.Отгон, БМА-ны дарга С.Алтанхуяг, жуух бичгээр СХА-ны ахлах инженер А.Баттүвшин, ҮА-ны статистик инженер Б.Оюунчимэг, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн шагнал болох “Тэргүүний төмөр замчин”-аар ТДЦ-ийн Техник диспетчер Р.Базарням, Ачаа вагон хүлээлцэгч Ц.Ариунжаргал, Дохиолол холбооны монтёр Б.Энхмаа, Илчит тэрэгний

машинч Ч.Болор-Эрдэнэ, “Төмөр замчны алдар”-аар ТДЦ-ийн Төмөр замын инженер Н.Баярбилэг, дохиолол холбооны инженер Д.Мөнхбаяр, “Хөгжлийн төлөө” шагналаар ТДЦ-ийн Нүүрс тооцооны инженер Ш.Амаржаргал нар тус тус шагнагдлаа.

Тус арга хэмжээний үеэр харилцагч байгууллагын нэр бүхий бүтээгдэхүүнээр азтан тодрууллаа. Үүнд :

Мобикомын VOO үйлчилгээний жилийн эрх:

- ТЦ Д.Ганзориг
- МЦ Ё.Нарангэрэл
- МЦ Э.Эрдэнэсолонго
- ЦЦ Д.Батсайхан
- МЦ С.Энхбат

Модерн номадс рестранаар үйлчлүүлэх 100.000 төг эрх

- ЗЦ Г.Түвшинтөр

Номин сүлжээ дэлгүүрийн 100.000 төгрөгийн эрх

- ТДЦ С.Энхтунгалаг
- ЗЦ В.Пүрэвсүрэн

Skytel Компанийн Go Plus Үйлчилгээний эрх

- ДХХАЦ Н.Намхайсүрэн
- ЦЦ Ням-Очир

Самсунг А-14 гар утас

- ТЦ Б.Даваадорж

Супер шагнал

- ЗЦ Б.Сайнтөр нар шалгарлаа.



2023 ОНЫ 8-Р САРЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төлөвлөгөөний биелэлт

Горимын даалгавараас 1828,377 мян.кВтц цахилгаан эрчим хүч илүү үйлдвэрлэж, 2574,566 мян.кВтц-аар зөрчиж, төлөвлөгөөг 746,189 мян.кВтц-аар тасалсан. Цахилгаан эрчим хүчний доод ачаалал 351 МВт, дээд ачаалал 464 МВт байлаа.

Диспетчерийн графикийн төлөвлөгөөний биелэлт

Үзүүлэлт	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт,%
ЦЭХ-ний түгээлт	сая.кВтц	286.4	285.6	-0.8	99.7%
ДЭХ-ний түгээлт	мян.Гкал	168.8	168.8	-	100.0%

Тайлант хугацаанд диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө: ЦЭХ - 99,7%, ДЭХ - 100,0% биеллээ.

ДҮТ-ийн диспетчерийн зохицуулсан төлөвлөгөө болон биелэлт

Нэмэх шийдвэр		Хасах шийдвэр		Диспетчерийн графикийн зөрчил		Ачаалал		Диспетчерийн төлөвлөгөөний биелэлт	Диспетчерийн графикийн нэмэх зөрчил
Удаа	мян. кВтц	Удаа	мян. кВтц	Удаа	мян. кВтц	Дээд	Доод	мян. кВтц	мян. кВтц
77	1828.377	11	796.777	3	2574.566	464	351	-746.189	-

СПОТ зах зээлийн талаар

СПОТ арилжааны зах зээлд 149,883 мян.кВтц буюу 8655,183 мян.төгрөгний цахилгаан эрчим хүч худалдаж, 85,93 мян.кВтц буюу 2288,766 мян.төгрөгний ЦЭХ худалдан авч, авлага өглөгийн зөрүүгээр 6,4 сая.төгрөгний авлагатай ажиллалаа. Өссөн дүнгээр 123,9 сая.төгрөгийн авлагатай.

Үйлдвэр санхүүгийн төлөвлөгөөний биелэлт

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг төлөвлөлтөөс 13,8 сая.кВтц-аар давуулан 105,1%-н биелэлттэй, оны эхнээс 123,9 сая.кВтц-аар давуулж, 104,7% -ийн биелэлттэй байна.

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 8-р сартай харьцуулбал 12,8 сая.кВтц буюу 4,7%-н өсөлттэй байлаа.

Дулааны эрчим хүчний түгээлт 19,0 мян.Гкал-аар тасарч 89,9%-н биелэлттэй, харин оны эхнээс нийт дулааны төлөвлөгөөг 20,9 мян.Гкал-аар давуулан биелүүлсэн байна.

Дулааны эрчим хүчний түгээлтийг өнгөрсөн оны 8-р сартай харьцуулбал 5,4 мян.Гкал буюу 3,1%-н бууралттай байлаа.

Үндсэн тоноглолын ажиллагаа

Горим ажиллагаанд 6 зуух, 6 турбин оролцсон. Сарын дунджаар 4,78 зуух, 4,88 турбинтэй ажиллаж, бэлтгэлд зуух, турбингүй ажилласан.

Мазутын зарцуулалт

Энэ сард 120 тн мазут түлэх төлөвлөгөөтэйгээс 89 тн-г түлж, 31 тн мазут хэмнэсэн.

Тайлант хугацаанд 4 удаагийн хүйтэн галлагаанд 86 тн мазут түлсэн. Нэг хүйтэн галлагаанд дунджаар 22 тн мазут зарцуулсан байна. Тайлант хугацаанд зуух №3 -г их засвараас галласан бөгөөд экранд үлээлт гарч 2 удаа зогссон 2 удаагийн галлагаанд 39 тонн мазут түлсэн. Мөн К-3 Mill-3d аваариар зогссон үед 3 тонн мазут түлсэн. /доргионы хамгаалалтаар/

Нүүрсний зарцуулалт /УСТ тарифт тусгагдсан нүүрснээс/

Уурхай	Нэгж	Тухайн сарын			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Биелэлт
Багануур	мян.тн	180.0	178.3	-1.712	99.0%
Шивээ-Овоо	мян.тн	130.0	141.2	+11.221	108.6%
Бүгд	мян.тн	310.0	319.5	+9.509	103.1%

Жишмэл түлшний зарцуулалт

Цахилгаан эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 2,294гр/кВтц-аар,

Дулааны эрчим хүч түгээхэд зарцуулах жишмэл түлш: 0,31кг/Гкал-аар хэмнэж гүйцэтгэлд ноогдох төлөвлөлтөөс 708 тн жишмэл түлш буюу 1565 тонн бодит түлш /илчлэг 3167 ккал/кг/ хэмнэсэн.

Горим параметрийн даалгаврын биелэлт

ЭХЗХ -аас батлагдсан ДХЦЭХ-ний зарцуулалтыг 0,45%-иар буюу 1444,559 мян.кВтц-аар хэмнэж ажилласан.

Нэгж бүтээгдэхүүнд оногдох ЦЭХ-г гүйцэтгэлд ноогдох төлөвлөгөө, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй тус, тус харьцуулбал:

№	Үзүүлэлт	Нэгж	8-р сар	
			Төлөв	Гүйц
1	1 тн нүүрс нунтаглахад зарцуулах цахилгаан	кВтц/тн.нүүрс	29.01	27.88
2	1 тн уур боловсруулахад зарцуулах үлээлт соролтын цах.	кВтц/тн.уур	4.35	4.18
3	1 тн тэжээлийн ус шахахад зарцуулагдах цахилгаан	кВтц/тн.тэж ус	8.54	8.21
4	Эргэлтийн усны насосд зарцуулагдах цахилгаан	%	1.55	1.49
5	Дулаанжуулалтын насосд зарцуулагдах цахилгаан	кВтц/Гкал	0.61	0.58

Уур усны алдагдал

Станцын дотоод циклийг нөхөх химийн цэвэрлэсэн усны зарцуулалтыг төлөвлөсөн хэмжээнээс 0,25%-аар бууруулж ажилласан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад химийн цэвэрлэсэн усны зарцуулалт 346 тн-оор нэмэгдсэн байна.

Дотоод циклийн алдагдлыг нөхөхөөр:

- Турбинд: 65618 м3
- Зууханд: 227 м3 ус өгсөн.
- БКВ-аас цэвэрлэгдсэн конденсатын зарцуулалт - 5472 м3 байлаа.



2023 ОНЫ 8-Р САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2023 оны 8-р сард станцын хэмжээний аваари, 1 болон 2-р зэргийн саатал гараагүй, үндсэн тоноглолын зогсолт 5 бүртгэгдсэнээс зуух 3 удаа, турбин 2 удаа зогссон.

№	Зогсолтын шалтгаан	Хамгаалалтаар		Захиалгаар		Бэлтгэлд		Саатал, гэмтлээр		Нийт зогсолт	
		2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар
1	Зуух	1	2	2	-	-	-	1	1	4	3
2	Турбин	1	-	-	1	-	-	6	1	7	2
	Дүн	2	2	2	1	-	-	7	2	11	5

Үндсэн тоноглолын зогсолт болон туслах тоноглолд бичигдсэн актууд:

- Тоног төхөөрөмжийн гэмтлийн акт: ЦЦ-3 (1.583.526 ₮), МЦ-1 (2.120.074 ₮) Бүгд-4 (3.703.600 ₮)
- Мазут зарцуулалтын акт: ЗЦ-2 (91.289.890 ₮) Бүгд-2 (91.289.890 ₮)
- Тоног төхөөрөмж, сэлбэг материал ашиглалтаас хасах акт: ЦТДЦ-1 (0₮), ЗЦ-1 (9.887.732 ₮), ТЦ-3 (0₮), ЦЦ-3 (1.173.993₮), ДХХАЦ-1 (0₮) Бүгд-9 (11.061.725₮)
- Уур, усны горимын зөрчлийг судалсан акт: ТЦ-1 (2.320.421₮) Бүгд-1 (2.320.421₮)

Нийт 16 ширхэг (108.375.636 төгрөг) акт тогтоогдсон.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн байдалд хийсэн хэмжилт. (Нэг удаагийн)

№	Цех нэгжүүд	Дуу шуугиан (85 дБ)		Ажлын байрны халуун (12-30 °С)		Ажлын байрны чийглэг (30-60 %)		Ажлын байрны тоосролт (10 мг/м³)		Тайлбар
		2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	2022 оны 8-р сар	2023 оны 8-р сар	
1	ТДЦ	75.9	66.7	23.1	21.1	58.5	71.1	17.3	7.77	
2	ЗЦ	83.4	82.8	31.0	30.9	35.2	42.5	10.5	6.44	
3	ТЦ	78.6	78.6	27	34.5	43.7	35.4	13.9	7.1	Станцын дундаж тоосролт
4	Хими	76.1	75.5	25.9	24.4	41.9	59.5			
5	Механик	82.4	84	26.9	26.4	37.2	58			

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ

1. Хяналтын чиглэлээр

№	Хийгдсэн ажил	Гүйцэтгэл	Тайлбар
1	Нарядын мөрдөлтөнд хяналт хийсэн байдал	100%	70 нарыдад сонголтоор хяналт хийсэн.
2	Ажлын байранд хяналт хийсэн байдал	100%	Цехүүдийн хийгдэж байсан ажлууд хяналт тавьж эргэлт хийсэн. Зуух турбин заалаар эргэлт хийсэн. ЭШМ -н дагуу хяналт тавьсан.
3	Шинэчлэл, засварын ажлын явцад хяналт хийсэн байдал	100%	К-5,7, ТА-2.6 засварын ажлууд, гэрээгээр ажиллаж байгаа гадны гүйцэтгэгч компанийн ажилд хяналт тавьсан.

2. Сургалт, зааварчилгаа

1	Урьдчилсан зааварчилгаа өгөгдсөн байдал	100%	146 хүнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
2	Шинээр ажилд орж байгаа иргэний сургалтын талаар	100%	30 иргэнд урьдчилсан зааварчилгаа өгсөн.
3	Ажлын байр өөрчлөгдсөн ажилтны сургалтын талаар	100%	Ажлын байр өөрчлөгдсөн 28 ажилтанд сургалт хийсэн байдалтай танилцсан.
4	Бусад сургалтын талаар	100%	Станцад ажиллаж байгаа ЗЦ, ТЦ, МЦ-ийн цахилгаан тоног төхөөрөмж дээр ажилладаг 7 ажилтнаас ААД-ийн групп-ын шалгалт давтан авсан. Тэнцсэн.

3. Хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар


1	МХЕГ ХАВҮЛ-тай байгуулсан гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих.	100%	ЭЗЦГ-н 3-р улиралд хийгдэх шинжилгээ хийгдсэн. Үүнд: Ундны ус-3, арчдас-10, Агаар-2, Хоолны дээж нийт -10 порц өгсөн. /хими-5, Нян-5/ Хэвийн.
2	Хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийх.	100%	Үндсэн 6 цехд хөдөлмөрийн нөхцлийн хэмжилт хийсэн. ТДЦ, МЦ ХЦ-д гэрэлтүүлэгийн хэмжилт хийсэн.
3	Ундны усны шүүлтүүр солих ажилд хяналт тавьсан талаар	100%	Хяналт тавьж байгаа.

4. Бусад ажлын талаар

- ХАБ-ын 3-р шатны үзлэг 7 цехэд удирдамжийн дагуу зохион байгуулсан протокол, үзлэгийн мөрөөр хийх ажлын төлөвлөгөө гаргасан.
- ЭХЯ-ны салбарын улсын байцаагчийн 01 тоот албан даалгаварын гүйцэтгэл гаргаж ЭХЯ-ны хяналтын газарт хүргүүлсэн.
- ОМД-2 дагуу хийх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл гаргасан.
- Хамтын гэрээний 13-р бүлэг буюу ХАБЭА талаар хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл гаргаж ЗХНА-д өгсөн.
- Эрчим хүчний сэтгүүлд тавигдах ХАБЭА-н мэлээлэл гаргаж СХА-д өгсөн.
- МОШПА -н сургалтанд 5 ажилтаны бүрэлдэхүүнтэй Эрдэнэт хотод оролцсон..
- Эрчим хүчний баярын ээлжит бус зааварчилгааг бэлдэж түгээлт хийсэн.
- Аюулгүй ажиллагааны үнэмлэх шинэчлэх ажил хийгдэж байна.
- ХАБ-ын гарын авлага шинэчлэх ажил хийгдэж байна.

Хяналтын алба

ЧАТ GPT ГЭЖ ЮУ ВЭ?



Chat GPT гэж юу вэ?

Open AI-ийн бүтээсэн ChatGPT буюу **Chat Generative Pretrained Transformer** нь AI болон машин сургалтын дэвшилтэт алгоритмуудыг ашиглан текст үүсгэх, асуултад хариулах томоохон хэлний загвар юм. Сүүлийн өдрүүдэд ChatGPT нь маш алдартай болж, янз бүрийн салбар, хэрэглээнд өргөн хэрэглэгдэж эхлээд байна.

ChatGPT-ийн талаарх сонирхолтой баримт, статистик

Microsoft компани **10 тэрбум долларын хөрөнгө оруулалт** ChatGPT-д оруулахаар төлөвлөж байгаа ба энэ нь уг компанийг **29 тэрбум доллараар үнэлж** буй хэрэг юм.

ChatGPT нь 5 хоногийн дотор нэг сая хэрэглэгчтэй болж 2 сарын дотор 100 сая хэрэглэгчтэй болсон байна (тэгвэл facebook 10-н сарын дотор нэг сая хэрэглэгчтэй болж байсан)

ChatGPT нь 175 тэрбум гаруй параметртэй хамгийн том хэлний загваруудын нэг юм. Энэ нь хүнтэй адил ~ хэл бүтээх чадвараараа олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд хиймэл оюун ухааны хэлний загварын салбарт тэргүүлэгч болж байна.

ChatGPT нь олон тооны чатботууд, вэб сайтууд болон гар утасны аппликейшнүүдэд нэгдсэнээр төрөл бүрийн хэрэгцээнд хүртээмжтэй болж байна. Гэхдээ ChatGPT нь юугаараа онцгой вэ, энэ нь таны өдөр тутмын амьдралд ямар ач тустай вэ?

Гол давуу талууд

- **Цаг хугацаа хэмнэдэг:** Хэлийг ойлгох чадвартай ChatGPT нь дахин давтагдах даалгавруудыг автоматжуулж, бичгээр харилцах шаардлагатай ажлуудад Таны цаг, хүчин чармайлтыг хэмнэнэ
- **Бүтээмжийг сайжруулна:** ChatGPT нь байнга асуудаг асуултуудад хариулах, контент бүтээх, хувийн зөвлөмж өгөх, цахим шуудан боловсруулах гэх зэргээр цаг хугацааг хэмнэж биднийг бусад ажилдаа анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгодог
- **Хэлний ур чадварыг сайжруулна:** ChatGPT-тэй дадлага хийснээр хэлний мэдлэгээ дээшлүүлж, илүү

үр дүнтэй, мэргэжлийн түвшинд харилцах боломжийг олгоно.

- **Уян хатан интеграцлалыг санал болгодог:** ChatGPT нь янз бүрийн платформд нэгтгэгдэж болох бөгөөд энэ нь таны тусгай хэрэгцээ, шаардлагад дасан зохицох чадах олон талын хэрэгсэл болно.

Хийх боломжтой Task-ууд

ChatGPT нь Англи хэл дээр task-ууд биелүүлдэг тул бид Англи хэл дээр шууд ашиглах боломжтой асуултуудын жишээг орчуулалгүйгээр орууллаа.

- Өгөгдөлд үндэслэн өгүүллэг, шүлэг бичих, өгүүлбэрийг дуусгах (Complete the following sentence: "The sun was setting behind the mountains and the sky was painted in shades of orange and pink. As the stars started to twinkle in the sky, I felt a sense of...")
- Асуултад хариулах, харилцан ярилцах (What is the capital of France?)
- Хэрэглэгчийн асуултуудад хариулах (How do I change my password on my account?)
- Chatbot-д шаардлагатай хариултуудыг боловсруулах (Can you provide me with some information on the latest smartphones?)
- Урт өгүүлбэр, мэдээллийг ерөнхийлөн дүгнэх (Summarize the article "The Future of Artificial Intelligence" in 5 sentences)
- Орчуулга хийх (Translate the sentence "Bonjour, comment ça va?" to English)



- Компьютерийн код бичих (can you write me a code for Tetris) гэх мэт олон зүйлсийг хийж болох нь байна.

Тэгвэл Chat GPT-г яаж ашиглах вэ?

OpenAI вэб сайт руу орж бүртгүүлээд өөрийн ашиглах төрлийг сонгоод л болоо юм байна. Мөн, ChatGPT нь туршилтын журмаар ажиллаж байгаа ба сайжруулалтууд тогтмол хийгдэж байгаа тул зарим мэдээлэл болон мэдээллийн эх сурвалж нь алдаатай, учир дутагдалтай байгааг уншигч та анхаараарай. Ямартай ч, өдөр тутмынхаа амьдралд хиймэл оюун ухааныг ашигласнаар бид хэл сурах, мөнгө олох, төрөл бүрийн жижиг ажлуудаа хийхэд маш хялбар болж байна.

/Эх сурвалж: <https://mailchi.mp/6amclub/>

That Might Motivate You №17

